

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2023.12.25

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго, арга зүй:

Зам, тээврийн хөгжлийн яамны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Хоёр. Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар:

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд 5 зорилтын нийт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 12, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн 1, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн 1 арга хэмжээний дундаж үнэлгээ **92.8** хувь байна. Дараах хүснэгтээр төлөвлөгөөний хэрэгжилтийг үзүүлбэл:

/Хүснэгт 1/

№	Төлөвлөгөөнд туссан зорилт	Арга хэмжээ тоо	Үнэлгээ /хувиар/					ХШҮ	
			100	90	70	50	30		0
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	4	3		1				92.5
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2	2						100.0
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	2	2						100.0
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3	2				1		76.6
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	3	3						100.0
Нийт		14	12	-	1	-	1	-	92.8

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд “30-70” хувиар үнэлэгдсэн 2 арга хэмжээ байна.

/Хүснэгт 2/

№	Арга хэмжээ	Хэрэгжилт
1	1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг	Зам, тээврийн салбарын 1800 гаруй албан хаагчдыг хамруулсан судалгааг цахимаар авч авлигаас

	нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах	урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний зөвлөмж боловсруулсан албан бичгээр харьяа байгууллагуудад хүргүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд харьяа байгууллага бүр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 А/303 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 21 аймаг бүрд салбарын үйл ажиллагааг сурталчилах, Авлигаас урьдчилсан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулсан. Зам, тээврийн хөгжлийн яам болон "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Ган зам пресстэй хамтран 2 төрлийн сурталчилгааны материал боловсруулж, яам болон "УБТЗ" ХНН-ийн цахим бүх сүлжээгээр дамжуулан 2 сарын хугацаанд 4 удаагийн давтамжаар олон нийтэд хүргэсэн. Мөн "УБТЗ" ХНН-ийн вагон болон гол замын хэмжээний Улаанбаатар, Дархан, Сайншанд, Замын-Үүд зэрэг буудлуудад сурталчилгааны материалыг байршуулсан. /Хэрэгжилт 70%/
2	4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын албан хаагчдаас авлигын эрсдэл болон үйл ажиллагааны хүндрэлийн талаар судалгаа авсан бөгөөд Албан хаагчдаас авсан судалгааны дүнгээр авлигын мэдлэг мэдээлэл сайжирсан ба 2024 оны төлөвлөгөөнд нарийвчлан тусгахаар удирдлагаас чиглэл ирүүлсэн. Мөн Авлигтай тэмцэх газрын 2 удаагийн үйлчлүүлэгчдээс судалгаа авсан. /Хэрэгжилт 30%/

3. Үнэлэлт, дүгнэлт:

3.1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын дагуу Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Доорх хүснэгтээр үнэлгээг нэгтгэж үзүүлэв.

/Хүснэгт3/		
№	Арга хэмжээ	ХШҮ /хувиар/
1	1.1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх	100
2	1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	70
3	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах	100
4	1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх	100
Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх 1-р хэсгийн үнэлгээний дундаж хувь		92.5
5	2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	100

6	2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах	100
Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах 2-р хэсгийн үнэлгээний дундаж хувь		100
7	3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх	100
8	3.2. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	100
Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох 3-р хэсгийн үнэлгээний дундаж хувь		100
9	4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	100
10	4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх	100
11	4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах	30
Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах 4-р хэсгийн үнэлгээний дундаж хувь		76.6
12	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах	100
13	5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал	100
14	5.3. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах	100
Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх 5-р хэсгийн үнэлгээний дундаж хувь		100
Нийт		92.8

3.2. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн яам нийт 14 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, жилийн эцсийн байдлаар дундаж үнэлгээ 92.8 хувьтай байна.

3.3. Тус яамны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг Авлигатай тэмцэх газраас 2022 оны жилийн эцсийн байдлаар 30 хувь, 2023 оны хагас жилийн байдлаар 80 хувиас бууруулж, 66,9 хувиар үнэлсэн байна. Энэ нь төлөвлөгөөний хэрэгжилт шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, зорилтод түвшинд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Санал, зөвлөмж:

4.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд хэрэгжилт хангалтгүй байгааг анхаарч, яамны албан хаагчид болон салбарын хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой уулзалт, сургалт зэрэг бодит арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тухай бүр тооцож ажиллахыг ТЗУГ-т;

4.2. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг боловсруулахад суурь түвшин, зорилтод түвшин, хэрэгжүүлэх хугацаа зэрэг үзүүлэлтийг тодорхой тусгах, яамны болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хариуцсан нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан батлуулахыг ТЗУГ-т;

4.3. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд туссан арга хэмжээг /уулзалт, зөвлөгөөн, сургалт, өдөрлөг зохион байгуулах, мэдээ, мэдээлэл, контент бэлтгэх, хэвлэмэл хуудас болон мэдээллийн самбар байршуулах/ хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, өртөгийн тооцож, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан арга хэмжээ тус бүрийг эзэнжүүлэхийг ТЗУГ-т;

4.4. Харьяа байгууллагуудын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хянах, батлах, зам, тээврийн салбарын хэмжээнд Авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр харьяа байгууллагуудтай хамтран ажиллахыг тус тус зөвлөж байна.

**АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Арга хэмжээ	Биелэлт	ХШҮ /хувиар/
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх			
1	1.1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн шторк, нийтлэл зэргийг тус яамны mtrd.gov.mn цахим хуудас болон Зам, тээврийн хөгжлийн яамны фэйсбүүк, истаграмм хуудсаар тухай бүр мэдээлж ажилласан. Шүгэл ажиллагааны хүрээнд "Авлигын эсрэг нэгдье" аянд тус яам нэгдэж, салбарын хэмжээнд соён гэгээрүүлэх ажиллагаа зохион байгуулсан. Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс 2023 оны 11 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулсан тээврийн 7 хоног олон улсын арга хэмжээнд АТГ-аас бэлтгэсэн зурагт хуудас гарын авлагыг 3 хоногийн турш олон нийтэд хүргэсэн.	100
2	1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	Зам, тээврийн салбарын 1800 гаруй албан хаагчдыг хамруулсан судалгааг цахимаар авч авлигаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний зөвлөмж боловсруулсан албан бичгээр харьяа байгууллагуудад хүргүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд харьяа байгууллага бүр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 А/303 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 21 аймаг бүрд салбарын үйл ажиллагааг сурталчилах, Авлигаас урьдчилсан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулсан. Зам, тээврийн хөгжлийн яам болон "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Ган зам пресстэй хамтран 2 төрлийн сурталчилгааны материал боловсруулж, яам болон "УБТЗ" ХНН-ийн цахим бүх сүлжээгээр дамжуулан 2 сарын хугацаанд 4 удаагийн давтамжаар олон нийтэд хүргэсэн. Мөн "УБТЗ" ХНН-ийн вагон болон гол замын хэмжээний Улаанбаатар, Дархан, Сайншанд, Замын-Үүд зэрэг буудлуудад сурталчилгааны материалыг байршуулсан.	70
3	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарыг тус яамаар үйлчлүүлж буй иргэдэд хялбар танилцаж болохуйц байршилд байршуулж, мэдээллийг 2023 оны тайлант хугацаанд 4 удаа шинэчилсэн.	100
4	1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын	Зам, тээврийн хөгжлийн яам болон "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Ган зам	100

	эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх	пресстэй хамтран 2 төрлийн сурталчилгааны материал боловсруулж, яам болон "УБТЗ" ХНН-ийн цахим бүх сүлжээгээр дамжуулан 2 сарын хугацаанд 4 удаагийн давтамжаар олон нийтэд хүргэсэн. Мөн "УБТЗ" ХНН-ийн вагон болон гол замын хэмжээний Улаанбаатар, Дархан, Сайншанд, Замын-Үүд зэрэг буудлуудад сурталчилгааны материалыг байршуулсан. Зам, тээврийн салбарын 1800 гаруй албан хаагчдыг хамруулсан судалгааг цахимаар авч авлигаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний зөвлөмж боловсруулсан албан бичгээр харьяа байгууллагуудад хүргүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд харьяа байгууллага бүр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 А/303 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 21 аймаг бүрд салбарын үйл ажиллагааг сурталчилах, Авлигаас урьдчилсан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулсан.	
2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах			
5	2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	Тайлант хугацаанд тус яамны төрийн захиргааны нийт 20 орон тоог олон нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтаар төрийн албанд анх удаа томилогдож буй албан хаагч байхгүй ба шинээр томилогдсон албан хаагчдад албан хэрэг хөтлөлт, салбарын хууль, эрх зүйн орчин, авлигын эрсдлээс сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулсан.	100
6	2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах	Монголын авто замчдын холбоо, автотээвэрчдийн нэгдсэн холбоо ТББ, "Зам, тээврийн залуучуудын хөгжлийн зам зөвлөл" ТББ зэрэг байгууллагуудтай тус яамны хувьд хамтран ажилладаг. Монголын авто замын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2023 оны 06 дугаар сард Төрийн ордонд зохион байгуулах үеэр Монгол Улсын Засгийн газраас шүгэл ажиллагааны хүрээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.	100
3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох			
7	3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх, гэрээ цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн	100

	хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх	төлүүлэх асуудлыг тухай бүр тусган ажиллаж байна.	
8	3.2. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу худалдан авах үйл ажиллагаа, тус яамны сул орон тоо, сонгон шалгаруулалтын зарлал гэх мэт нийт 67 үйл ажиллагааг нийтэд ил тод байдлаар тус яамны mrt.d.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Шилэн дансны мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд тухай бүр байршуулж байна.	100
4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах			
9	4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу худалдан үйл ажиллагаа, тус яамны сул орон тоо, сонгон шалгаруулалтын зарлал гэх мэт нийт 67 үйл ажиллагааг нийтэд ил тод байдлаар тус яамны mrt.d.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Зам, тээврийн салбарын нийт 94 үйлчилгээнээс 94 нь цахимжуулж иргэдэд илүү хүртээмжтэй болгосон.	100
10	4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх	Монголын авто замын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2023 оны 06 дугаар сард Төрийн ордонд зохион байгуулах үеэр Монгол Улсын Засгийн газраас шүгэл ажиллагааны хүрээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулж, авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, зохион байгуулсан. Мөн Зам, тээврийн салбарын залуучуудын III-р чуулганыг Ганзам Пласт 2023 оны 06 дугаар сарын 27-нд зохион байгуулж, тус чуулганы үеэр мөн Засгийн газрын авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны талаар танилцуулж, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.	100
11	4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах	Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын албан хаагчдаас авлигын эрсдэл болон үйл ажиллагааны хүндрэлийн талаар судалгаа авсан бөгөөд Албан хаагчдаас авсан судалгааны дүнгээр авлигын мэдлэг мэдээлэл сайжирсан ба 2024 оны төлөвлөгөөнд нарийвчлан тусгахаар удирдлагаас чиглэл ирүүлсэн. Мөн Авлигатай тэмцэх газрын 2 удаагийн үйлчлүүлэгчдээс судалгаа авсан.	30
5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх			
12	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг	Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны	100

	үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах	төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн мэдээллийн цаг арга хэмжээний үеэр нийт албан хаагчдад танилцуулсан.	
13	5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал	Тус яамнаас зам тээврийн сайдын 2023 оны А/222 дугаар тушаалаар баталсан Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журамд 2 удаа АТГ аас санал авсан. ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Дугаар А/199 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ, ОНОШЛОГОО ЯВУУЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1. "Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журамд нэг удаа санал авсан АТГ ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна	100
14	5.3. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах	Салбарын хэмжээнд Авлигатай тэмцэх төлөвлөгөөг байгууллага бүр баталж мөрдүүлэхийг чиглэл болгож, тус яамны харьяа нийт 10 байгууллага нь авлигатай эсрэг төлөвлөгөө боловсруулсан. 2023 оны жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн гаргаж байна. 2024 оны нэгдүгээр улиралд дүгнэж, санал зөвлөмж хүргүүлнэ.	100
Нийт			92.8

ЗТХЯ.